



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 331

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.2, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, 28.1, 63 дугаар зүйлийн 63.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Райнос инвестмент” ХХК-д үнэт цаасны брокер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус олгосугай.

2. Үнэт цаасны брокер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Райнос инвестмент” ХХК /На Жин Сү/-д үүрэг болгосугай.

1/ Холбогдох хууль, тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, харилцагч, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн ажиллах;

2/ Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан зохих өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН